



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/06

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Глобал жэт” ХХК нэхэмжлэл гаргасантай холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.2.1, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дахь заалтуудад заасан бүрэн эрхийг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Б.Мөнхжаргал/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, тусгай хамгаалалтай газар нутаг хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнх-Эрдэнэ/ нарыг аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр (хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар) томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газар Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Б.Мөнхжаргал/, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнх-Эрдэнэ/ нарт даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/439 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010046